

**ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН ТАЙЛАН МЭДЭЭ**

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэдээлэл:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Төлөөлөгчийн өдөр"-ийг тогтоох тухай тогтоолын хэрэгжилтийг хангах, иргэд, байгууллагын оролцоо, санал хүсэлтийг хүлээн авах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эргэх холбоог сайжруулах зорилгоор "Төлөөлөгчийн өдөр"-ийг Биндэр суманд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгууллаа. Хэнтий аймагт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.

Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 42 дугаар Зарлигаар "Монгол цэргийн өдөр", Казак түмний "Наурыз" баярыг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт бүтээл гаргаж, гавьяа байгуулсан Хэнтий аймгийн нэр бүхий иргэдийг шагналаа. "Алтан гадас одон"-гоор Хэрлэн сумын "Суно" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн механик инженер Чакейн Болатжан, Бэрх хотын ахмад настан Садвекасын Кааж нар, "Цэргийн гавъяаны улаан тугийн одон"-гоор аймгийн Цагдаагийн газрын ахмад ажилтан, бэлтгэл хошууч Цэвэгсүрэнгийн Базаррагчааг, Хэрлэн сумын 5 дугаар багийн иргэн Санжийн Төмөрхүү "Шударга журам" медалиар тус тус шагнасан байна.

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 240 бичиг ирснээс хугацаатай бичиг 24 бүртгэгджээ. Үүнээс 24 бичиг шийдвэрлэх шатандаа явж байна. 174 бичиг явсан. Улаанбаатар хот болон сумдын шуудангийн хуваарийн дагуу, Улаанбаатар хот руу 51, сумд руу 49 бичиг илгээгджээ.

Сарын эхэнд Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшингээр ахлуулсан Улсын Онцгой комиссын ажлын баг ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, мэргэжлийн удирдлага, шуурхай зохион байгуулалтаар хангах, төр, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Хэнтий аймгийн Жаргалтхаан, Мөрөн, Хэрлэн Батноров сумд, Бэрх тосгонд ажиллав.

Сангийн яам, Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Тогтвортой Амьжиргаа-III" төслөөс ОНХС-ийн журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан санг төлөвлөх болон төсөл, арга хэмжээг эрэмбэлэх сэдэвт сургалтыг 03-р сарын 11-24-ний өдрүүдэд Хэнтий аймагт зохион байгууллаа. Сум бүрээс багийн Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын дарга, ОНХС-ийн сумын ажлын хэсгийн гишүүдийг хамруулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, аймгийн хэмжээнд 200 шахам хүн хамрагдлаа.

Сумдын Хөдөө аж ахуйн болон, мал аж ахуйн мэргэжилтнүүдийн зөвлөгөөн боллоо. Мөн атар газар эзэмшсэний 60 жилийн ой, хаврын тариалалтын улирал эхэлж байгаатай холбогдуулан тариаланчид, хүнсний ногоочдын зөвлөгөөн боллоо.

"Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд аймгийн "Удирдах ажилтны гуравдугаар зөвлөгөөн" гуравдугаар сарын 25-ны өдөр боллоо. Зөвлөгөөнд аймгийн удирдлагуудаас гадна 30 агентлаг, газар хэлтсийн удирдлагууд, 18 сумын ИТХ-ын дарга, хурлын

нарийн бичгийн дарга нар, Сумдын Засаг дарга нар, Тамгын газрын даргын нар, 27 сургуулийн захирал, 26 эмнэлэг, эрүүл мэндийн төв, 30 цэцэрлэг, 23 соёлын төвийн эрхлэгчид, 30 гаруй байгууллагын дарга, удирдлагууд нийлсэн 250 шахам удирдах ажилтнууд зөвлөлдлөө. Зөвлөгөөний үр дүнд Аймгийн Засаг даргын 10 заалт бүхий албан даалгавар гарч удирдах ажилтнуудад хүрлээ.

Аймгийн Засаг дарга Н.Ганбямбаар ахлуулсан хууль, хяналтын байгууллагын мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг гуравдугаар сарын 16-нд Галшар суманд Жонш олборлох боловсруулах үйл ажиллагаа явуулдаг БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай Нордвинд ХХК-ийн Бичигтийн уурхайд гэнэтийн шалгалт хийж, МУ-ын хууль тогтоомж, холбогдох журам зөрчсөн хэд хэдэн зөрчил илрүүлж, уурхайн үйл ажиллагааг зогсоож, Аймгийн Цагдаагийн газраар шалгуулж байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ:

Төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу төсөвт байгууллага, нийгмийн даатгал, халамжийн сангууд зэрэг 92 байгууллагын төлбөр тооцоог анхан шатны баримттай нь тулган нийт 2304.4 сая төгрөгийн 1026 ширхэг гүйлгээг хийж, хянан баталгаажууллаа.

Төрийн сангийн кассын үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 43 төсвийн байгууллагын 13.4 сая төгрөгийг ХААН банкаар дамжуулан бэлнээр гаргаж төрийн сангийн үйлчилгээг үзүүлээд байна.

Аймгийн Засаг даргын нөөц сангаас 11 захирамжаар 12.1 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. ОНХ-Сан, сум хөгжүүлэх сангийн 2017 оны зарцуулалтын гүйцэтгэлээр зөрчил гаргасан байгууллагын албан тушаалтнуудад хариуцлага тооцож, арга хэмжээ авах тухай чиглэл ЗГХЭГазраас ирсний дагуу холбогдох хариуг сумдаас авч нэгтгэн хүргүүлэв.

АА-Нэгж байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нийт 1357 АА-Нэгж өгөхөөс 1170 буюу 86,2 хувьтай хүлээн авч нэгтгээд байна. Үүнээс НББ-ийн тухай хууль болон Сангийн сайдын 41-р тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх 8 ААНэгж, тайлан нь алдаатай 11 байгууллага нийт 19 байгууллагын тайланг одоогоор баталгаажуулаагүй шалгаж тодруулах ажил хийгдэж байна.

“Тогтвортой Амьжиргаа III” төслөөс сумдын багийн Засаг дарга нар болон холбогдох мэргэжилтэнүүдэд ОНХ-Сангийн шинэ журмын талаарх сургалт 3 дугаар сарын 11-ээс эхлэн явагдаж байна.

Татвар төлөлтийн байдал

Улсын төвлөрсөн төсөвт 37.6 сая төгрөг, орон нутгийн төсөвт 217.6 сая төгрөгийн татварын орлого тус тус төвлөрүүлэв. Татварын төрлөөр давхардсан тоогоор 555 татвар төлөгчтэй татварын тооцоо хийж, 10 ААН-д мэдэгдэх хуудас гардуулсан. Хоёр ААН-ийг шалгаж 22,1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 3,5 сая төгрөгийн шийтгэл оногдуулсан.

Орон нутгийн өмчийн газар

Цэргийн штабын командын байр барихад дэмжлэг үзүүлэх ажилд “Сайн ундрах” ХХК, Аймгийн тагнуулын хэлтэст тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг “Хөх гүрэн констракшн” ХХК гүйцэтгэхээр болсон.

Татварын хэлтсийн тохижилтын ажилд “Алсын солонго” ХХК, Мөрөн сумын багийн төвийн барилгын ажилд “Баялаг хурах” ХХК, Хэрлэн сумын 6-р багт хүүхдийн цэцэрлэг барих ажилд “Бүрдэн тойрог” ХХК, Дэлгэрхаан сумын ахмадын сувиллын цахилгааны ажилд “БСМГ” ХХК, АЗДТГ-ын автомашин нийлүүлэх ажилд “Грийн жем” ХХК тус тус шалгарсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар 2018 оны үйл ажиллагааны тайланг тавьж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний явцын талаар хэлэлцээд, тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажлыг шуурхайлан ажиллах үүрэг чиглэлийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэх шийдвэрийг гаргав.

Мөн орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн талаар хийгдсэн ажлын талаар мэдээлэл хийж улсын болон орон нутгийн төсвөөс чамгүй хөрөнгө зарцуулсан "Хэнтий Ус" ХХК-ийн эзэмшилд байдаг Гутлын үйлдвэр, "Өндөрхаан сүү" сүүний үйлдвэр, Ноосны үйлдвэр зэрэг үр ашгаа өгдөггүй объектуудын талаар тодорхой ажил зохион байгуулж, дэлгэрэнгүй судалгаа, саналыг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хуралдаанд оруулах зөвлөмж хүргүүлэв.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар батлагдсан захиргааны статистикийн мэдээллийн маягтууд /ТӨ-1, ТӨ-2, ТӨ-3, ТӨ-5, ТӨ-13.1, ТӨ-13.2, маягт-11 /-аар орон нутгийн өмчит байгууллагуудаас авч нэгтгэн ТӨБЗГазрын өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн н.Ганчимэгт цахимаар хүргүүлж ажилласан. ЗГХЭГ-т 1991-1996 онд хувьчлагдсан хөрөнгийн судалгааг гарган хүргүүлэв.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Хууль хяналтын үйл ажиллагаа:

ХЭЗХ-т ирсэн бичиг 15, явуулсан бичиг 8, эрх зүйн зөвлөгөөг 35 иргэнд өгч, хууль тогтоомжийн нэгдсэн сангаас лавлагаа авсан 15 иргэн байна.

Аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн үйлчилгээний төвийн 70563111 дугаарын утсанд ирсэн нэг өргөдлийг хүлээн авч харьяалах газар луу шилжүүлэн шийдвэрлэсэн.

Норовлин сумын, Засаг даргын тамгын газраас ирүүлсэн захирамж, тушаалыг хянаж хүргүүлээд байна.

Сумдын Засаг дарга нарт орон нутгийн үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай нийтээр дагаж мөрдөх тогтоол, шийдвэр, дүрэм, журам зэргийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргах, хуулиар эрх олгогдоогүй этгээд татвар, төлбөр хураамжийн хэмжээг тогтоож өөрт олгогдоогүй эрх эдлэх, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Хууль зүй дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй, хүчин төгөлдөр болоогүй шийдвэрээр иргэд, аж ахуйн нэгжээс төлбөр хураамж авч, Төрийн санд бүртгэлгүй дансанд төвлөрүүлэх зэрэг зөрчлүүд түгээмэл гаргасан байна. Иймд дээрх зөвлөмжид заасан зөрчил дутагдлыг арилгах зорилгоор хүчин төгөлдөр үйлчилж, нийтээр дагаж мөрдөж байгаа болон төлбөр хураамж тогтоосон Засаг даргын захирамжуудыг 2019 оны 3 дугаар сарын 01-ний дотор ирүүлж хянуулахыг мэдэгдлийг албан бичгээр хүргүүлсэн байна.

“Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөрийн хүрээнд сайн дураараа архинаас гарах 6 иргэний өргөдлийг хүлээн авч, аймгийн Нэгдсэн эмнэлгийн Наркологийн тасагт хэвтүүлэн хордлого тайлах, сэтгэл засал, дуршил бууруулах /спираль/ эмчилгээ хийлгэн. Засаг даргын орлогч Ц.Чогсомжав даргатай итгэлцлийн гэрээ хийв.

ЦГ, ХЭЗХ, Хэрлэнгийн цэнхэр алс ТББ-тай хамтарсан “Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөрийн хүрээнд ахлах, дунд ангийн сурагч нарын дунд “Архигүй амьдралын баяр баясгалан” гар зургийн уралдаан зохион байгуулах ажлыг төлөвлөв. Хүний эрхийн үндэсний комиссоос ирсэн зөвлөмж, тогтоолыг сумдын Засаг дарга нарт, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар луу чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг нэгтгэж, ХЭҮК-д хүргүүлсэн.

Нотариатын үүрэг хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалтны судалгааг бүх сумдаас авч нэгтгэн хүргүүлсэн.

“Хан голомт” ТББ-ын тэргүүн Ц.Азбаяртай 2019 оны 03 сарын 25-ны “Удирдах ажилтны гуравдугаар зөвлөгөөн”-д сургалт хийх гэрээг байгуулан ажиллав.

Архивын тасагт ирсэн бичиг 35, явуулсан бичиг 32, өргөдөл 3 ирсэн байна. Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах болон үзлэг явуулах ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан, “Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг”-ийг явуулах ажлын хэсгийн багийн хуваарийг хийж, аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд ажлын хэсгийн даргаар батлуулсан.

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Уулын баяжуулах үйлдвэрийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Батболдод шинжлэх ухаан, зураг төсөл, техник технологийн болон үйлдвэрийн захиргааны байнга хадгалах баримтуудаа төрийн архивын сан хөмрөгт шилжүүлэх тухай мэдэгдлийг албан бичгээр хүргүүллээ. Аймгийн Нийтийн номын сангийн ББНШК-ын байгуулах тушаалын болон комиссын дүрмийн төсөл, байгууллагын 2019 оны ХХНЖ-ийг хянаж, 18 заалтыг, Уламжлалт анагаах ухаан хүүхэд сэргээн засах төвийн 2019 оны ХХНЖ-ийг хянан үзэж, оруулсан саналыг албан бичгээр хүргүүлсэн.

Хэнтий аймгийн Архивын тасгийн дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай тушаалын төсөл болон ББНШАЗК-ын үйл ажиллагааны дүрмийн төслийг боловсруулан, хянуулж, батлуулахад бэлэн болгосон. Архивын улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээг цахим санд оруулах хугацаа сунгагдсантай холбогдуулан Хэнтий аймгийн төрийн архив болон хөмрөг үүсгэгч байгууллагын 2017 оны баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын талаарх мэдээг 90 байгууллагаас хүлээн авч цахим санд шивснийг, хянан баталгаажуулсан. Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 38 иргэнд 225 жилийн санхүүгийн, 11 иргэнд 79 жилийн мал тооллогын бүртгэлийн лавлагаа олгож, 15 иргэнд 556 хуудас удирдлагын баримтын хуулбар олгоод байна. Лавлагаа үйлчилгээнд удирдлагын болон санхүүгийн давхардсан тоогоор 148 хөмрөгийн 826 х/н-д эрэн хайлт хийсэн байна

Гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээлэл:

Нийт гэмт хэрэг 2018 оны байдлаар 107, 2019 оны байдлаар 140 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны гуравдугаар сартай харьцуулахад 30.8 хувиар өссөн гэмт хэргийн илрүүлэлт 25.5 хувтай байна.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр:

Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтнүүд Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулиуд, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа, үдийн цайны чанар хүртээмж, дотуур байрны орчинд

үнэлгээ хийж, багш нарын хичээлд сууж, хичээл бүрээр сурагчдын сурлагын төвшинг тогтоох хөндлөнгийн шалгалт авч, багш нарт зөвлөн туслах, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

03 дугаар сарын 19-21 ний өдрүүдэд БСШУСЯ-ны дэргэдэх боловсролын үнэлгээний төвөөс улс даяар нэгэн зэрэг Боловсролын чанарын үнэлгээний шалгалтыг ЕБС-ийн 3, 10-р ангийн сурагчдаас түүврийн аргаар, 9-р ангийн бүх сурагчдаас авч, битүүмжлэн явууллаа. Хэнтий аймгийн 22 ЕБС, СӨБ-ын 16 багш оролцсон “Тэгш хамруулан сургах боловсрол” сэдэвт чадавхижуулах сургалтыг 3 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд БСУГ, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын “Бор-Өндөр-2” ОНХ зохион байгууллаа. Жаргалтхаан суманд Олон улсын эко сургууль хөтөлбөрийн сүлжээнд Хэнтий аймгийн СӨББ-ын 19 цэцэрлэгийн 51 багш, удирдах ажилтнууд хамрагдаж, анхан шатны сургалтад хамрагдлаа.

Германы Ахмад мэргэжилтний албаны шугамаар Хэнтий аймаг дахь МСҮТ-д Герман мэргэжилтэн DR. Annetarie Goos нь 2019 оны 3-р сарын 12-оос 4-р сарын 06-ны өдрүүдэд тус сургууль дээр хэрэгжиж байгаа Чанарын менежментийн тогтолцоо олон улсын ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд зөвлөхөөр ажиллаж байна. Тус зөвлөх нь Герман улсдаа мэргэжлийн сургуулийн захиралаар 14 жил ажилласан туршлагатай хүн юм.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ДЗМОУБ-ын “Бор-Өндөр 2” ОНХХ, “Эргэх холбоо” ТББ-ууд хамтран “Жишиг сум” хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсон бөгөөд Баян-Адрага сумыг сонгон тус суманд ажиллалаа. Энэхүү төсөлт арга хэмжээний хүрээнд зорилтот сумын гэр бүл, хүүхэд, залуучууд руу чиглэсэн хөтөлбөрт арга хэмжээг сар бүр тогтмол зохион байгуулж, “Бор-өндөр 2” ОНХХ-ийн зүгээс бичил төслүүдийг дэмжин ажиллах юм. Жил тутам зохион байгуулдаг, “Дуулах өв-2019” уралдааныг Хэнтий аймгийн Дадал сумаас төрөн гарсан Монгол улсын ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар, Сүхбаатарын одонт Оросын холбооны Буриад улсын ардын жүжигчин, ХХ зууны манлай дуурийн дуучин, профессор Цэвэгжавын Пүрэвдоржийн мэндэлсний 90 жилийн ойг тохиолдуулан, түүний нэрэмжит болон зохион байгуулжээ.

Эрүүл мэндийн чиглэлээр:

ДЭМ-Байгууллагын Ази номхон далайн баруун эргийн бүсийн суурин төлөөлөгч болон Геронтологийн төвийн дарга, мэргэжилтнүүд орон нутагт ирэн, Аймгийн даргатай хамтран ажиллах талаар санал солилцож, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эмнэлгүүд, сумдын ЭМТөв, Ахмадын хороо зэрэг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай танилцлаа.

Баянмөнх сумд зохион байгуулагдсан “ХАН ХЭНТИЙ ЭМЭГТЭЙЧҮҮД МАНЛАЙЛАЛ” ЧУУЛГА УУЛЗАЛТ-д оролцсон эмэгтэйчүүдэд “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” үзүүлэх Мобайл технологиор үзлэг оношлогоо хийж, давхардсан тоогоор 126 хүнийг хамруулж зөвлөгөө өгөв.

Гэр бүл, хүүхэд, Залуучуудын хөгжлийн газартай хамтран Хорих 419-р ангийн нийт 130 хүмүүжигч залууст сургалт зохион байгуулж, БЗДХӨ-ний шинжилгээнд хамрууллаа.

ЭМЯам дээр зохион байгуулсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хоёрдугаар шатны хэлэлцүүлэг”-т холбогдох дарга, мэргэжилтнүүд оролцов.

Нийгмийн хамгааллын чиглэлээр:

БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдээс авах Солонгос хэлний төвшин тогтоох шалгалт (СХТТШ)-ын бүртгэлийг амжилттай зохион байгуулж, квотын дагуу 60 хүн бүртгэв.

2019 онд хэрэгжих Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт ирсэнтэй холбогдуулан, холбогдох зарыг байгууллагын веб хуудас, мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. Хүнсний эрхийн бичиг олгох журмын 1.3-т заасны дагуу тус үйлчилгээнд хамрагддаг 18-60 насны 2-р багийн 150 иргэдийг Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Мөн энэ үеэр 140 гаруй иргэдийн хувийн хэргийг шинэчлэн бүртгэсэн юм. Энэ 7 хоногт 3-р баг дээр ажиллаж байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд 18 сумын 89 багт 10,8 мянган малчин, мал бүхий өрхөд нийт 4,6 сая толгой буюу хонин толгойд шилжүүлснээр 8,1 сая толгой мал хаваржиж байна. Том малын зүй бус хорогдол 9874 толгой гарсан нь нийт малын 0.2 хувийг эзэлж байна. Төллөвөл зохих 2179582 хээлтэгчийн 5.6 хувь буюу 121100 толгой хээлтэгч төллөж, төл бойжилт 99.3 хувь буюу 120315 толгой төл бойжиж байна. Мөрөн, Хэрлэн сумын 3 суурийн үхэрт галзуу өвчин оношлогдон сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/27 тоот захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоон хэрэгжүүлэн ажиллаж байна. Голомтод сүүлийн 13 хоногт мал амьтан өвчлөөгүй.

Өлзийт тосгоны нэг суурьт гарсан малын халдварт галзуу өвчний дэгдэлт, халдварлалтыг зогсоох зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ариутгалын автомашинаар голомтын ойр орчмын 12 айл өрхүүдийн малын хашаа саравч /1200 м² /, 4 уст цэг /3600м²/, саалийн механикжсан “Атар чандгана сүү” ХХК-ны байр, хашаа , саравч /3150м²/ нийт 7950 м² талбайг хамруулан ариутгал хийсэн. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 23 өрхийн 36 нохой, 34 өрхийн 704 үхэр хамрагдаад байна.

ЗУРГАА. БАЙГАЛ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгал орчны чиглэлээр:

Хэнтий аймгийн сум болон сум дундын ойн ангийн ойн инженер, ойн техникч нарыг газар зүйн мэдээллийн ArcGis программ хангамжийн мэдлэгийг дээшлүүлэх, аймгийн хэмжээний ойн мэдээллийн санг бүрдүүлэх, талбай тусгаарлалтын зураглал, ойн нөхөрлөлийн зураглал хийх сургалтыг 3 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгууллаа.

03 дугаар сарын 13-ны өдөр “Монгол Улсын 10 аймгийн төвийн дулаан хангамж сайжруулах төсөл”-ийн хүрээнд манай аймагт хийгдэж байгаа Дулааны цахилгаан станцын Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг танилцуулах олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох мэргэжилтэн, байгууллагуудыг оролцууллаа.

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:

2019 оны 03 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд МЭЕГазраас эпидемиологич эмч нарт “ARCGIS программ ашиглах арга зүйд эзэмшүүлэх” газар зүйн мэдээллийн системийн 7 хоногийн сургалтад Зооноз, халдварт өвчин тандалтын асуудал хариуцсан мэргэжилтнийг хамрууллаа. Бүсчилсэн хөгжлийн бодлогын Хэнтий аймаг дахь хэлэлцүүлгийг аймаг, сумын удирдлагууд, агентлаг, байгууллагын дарга, мэргэжилтнүүд болон иргэдийн төлөөлөл бүхий 280 гаруй хүнийг оролцуулан 2019-03-26-ны өдөр “Хан Хэнтий чуулга”-д зохион байгууллаа.

2019 оны 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан ИТМ-2019 аялал жуулчлалын үзэсгэлэнд Батширээт, Дадал, Биндэр, Дэлгэрхаан сумдын 10 ААН байгууллага, мод, модон эдлэл, гар урлаач иргэдийн бүтээл болон “Ёохор” эвент арга хэмжээг сурталчлан оролцлоо. Түүнчлэн Хэнтий аймаг Монголын аялал жуулчлалын холбооны 2020 оны түнш аймгаар сонгогдож шилжин явах туг хүлээн авч, аймгийн Засаг дарга хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, аймгийн хэмжээнд 2019 онд иргэнд өмчлүүлэх байршил, хэмжээ, зориулалтыг баталсан аймгийн ИТХ-ын тогтоолын нэгдүгээр улирлын хэрэгжилтийг сумдаас хүлээн авч нэгтгэн ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 8.1.8-д заасны дагуу журмын 4-р хавсралтын дагуу тайлан мэдээг гаргаж Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэв

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

БАТШИРЭЭТ СУМ

2019 оны 03 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд сумын 4 багийн иргэдийн нийтийн хуралд ИТХ-ын дарга Д.Гансүрэн, Засаг даргын орлогч Б.Алтангэрэл, мөн багуудын Засаг дарга нар, холбогдох мэргэжилтнүүд, иргэд нийлсэн 230 хүн оролцов. Хурлаар багийн Засаг дарга нар 2018 оны хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа танилцуулж, иргэд, хөдөлмөрчдөөс санал хүсэлт авах ажлыг зохион байгууллаа.

Гурав дугаар сарын 02-нд “Эх орончдын өдөр”, МАН байгуулагдсаны 98 жилийн ойг тохиолдуулан “Волейбол”-ын тэмцээн, 05-нд зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг идэвхжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Эрүүл агаар-Хөдөлгөөн” явган аялал, 06-ны сумын албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудын хамтарсан “Зон олондоо өргөх дуун цацал” урлагийн тоглолт, 07-ны өдөр Хурх багийн аймгийн аварга малчин Ш.Сэдэд санаачлан ивээн тэтгэж “Хаврын найраг-2019” малчдын дундах дууны тэмцээнийг тус тус зохион байгуулагдав.

03 дугаар сарын 08-ны өдөр сумын ИТХурал, ЗДТГазар, Соёлын төв, УЗАШХороо хамтран өндөр настан Барх багийн иргэн Г.Тунгалаг, Б.Рина, Хурх багийн иргэн З.Амарзаяа нарын хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх “Сүүн замтай он жилүүд” хүндэтгэлийн тоглолт 21 “Хүмүүнлэг ээж”-ийг шалгаруулж шагнахаас гадна Харнууд овогт Пунцагийн Содномын дурсгалыг хүндэтгэж үр хүүхэд, ач зээ нараас нь 108 ээжид гарын бэлгийг гардууллаа. Тайлант сарын 09,10-ний өдрүүдэд Ерөнхий боловсролын сургуулийн төгсөлтүүд дунд уламжлал болон зохион байгуулагдсаар ирсэн “ТООНОТ ЦОМ” спортын наадам 5 дахь жилдээ боллоо. 16, 17-ны өдрүүдэд Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг сумын аварга шалгаруулах “Волейбол”-ын тэмцээн амжилттай болж өнгөрлөө. Тэмцээнд нийт 14 багийн 90 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс

Зэвсэгт хүчний 98 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-т зориулан 03 дугаар сарын 18-ны өдөр “Аврагч-2019” тэмцээн, 20-ны өдөр хүүхдийн “Буриад дуу-2019” тэмцээн 6 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж цэцэрлэгийн болон сургуулийн насны 40 гаруй хүүхэд оролцлоо.

БАЯНХУТАГ

3-р сарын 2,3,4-ний өдрүүдэд Жаргалант, Улаан-Өндөр, Цантын хоолой багуудын ИНХурал хуралдаж, хурлын үеэр мэргэжилтнүүд сургалт мэдээлэл хийж, багийн Засаг дарга нар 2018 оны үйл ажиллагааны тайлангаа тавьж, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулав. Гурван багийн Иргэдийн нийтийн хуралд нийт 256 иргэн оролцсон.

“Эргэх холбоо” ТББ, Сумын соёлын төвтэй хамтран Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийн төлөө” уулзалт, цэнгүүнийг зохион байгуулж 257 иргэн оролцсон.

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Сумын сайхан бүсгүй” шалгаруулах ГОЁЛ-2019 наадмыг амжилттай зохион байгуулж, 10 бүсгүй өрсөлдөж, дөрвийг нь өргөмжиллөө. Тус арга хэмжээг нийт 127 иргэн үзэж сонирхсон.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Есөн эрдэнийн ээж” хүндэтгэлийн арга хэмжээг ЗДТГазар, ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид, сумын эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 350 гаруй эмэгтэйчүүд хамрагдсан.

Баянхутаг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй "Хариуцлага ба хамтын ажиллагаа" уулзалт зөвлөгөөнийг 2019 оны 03 дугаар сарын 14-нд сумын иргэний танхимд амжилттай зохион байгууллаа. Тус уулзалт зөвлөгөөнд сум орон нутгийн удирдлагууд, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн дарга, захирал, төлөөлөл гэсэн нийт 17 хүн оролцсон.

Монгол цэргийн баярын өдөрт зориулж Монгол Улсын Ууган баатар Шагдарын Гонгорын нэрэмжит “Үндэсний шагайн харваа”-ны тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнийг аймгийн Цэргийн штаб, сумын ЗДТГазар, шагайн товчоо хамтран амжилттай зохион байгуулсан. Тэмцээнийг Дорнын нүүрс ХХК ивээн тэтгэсэн. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 98 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын ууган баатар Ш.Гонгорын хөшөөнд цэцэг өргөлөө. Цэцэг өргөх ёслолын арга хэмжээнд аймгийн Цэргийн штаб, сум орон нутгийн удирдлагууд, албан байгууллагуудын бүх эрчүүд, ЕБС-ийн сурагчид, иргэд нийт 80 гаруй хүмүүс оролцсон.

БАЯН-ОВОО СУМ

Эх орончдын баярт зориулсан үндэсний бөхийн барилдаан, “Эх орончид – Кино дэлгэцнээ” уралдаант тэмцээн, мэндчилгээ, асуулт хариулт, арга хэмжээ зохиов. “Эргэх холбоо-24” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨЛӨӨ ЭМЭГТЭЙЧҮҮД” уулзалт цэнгүүнийг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нээлт, Talk show, хэлэлцүүлэг буюу 9-н салбарын 9-н эмэгтэйг тодруулах, урлагийн тоглолт, 8-н шилдэг эмэгтэйг тодруулах, азтан тодруулах, үдшийн цэнгүүн гэсэн хөтөлбөрийн дагуу явагдаж нийт 198 бүсгүйчүүд хамрагдлаа. Мөн Баянмөнх сумын Засаг дарга М.Цэнгэл “Хүүхнүүдээ шивнээ байна” лекцийг тавьж 99-н хүн хамрагдлаа.

Зэвсэгт хүчний 98-н жилийн ой, Халхын голын ялалтын 80 жилийн ой, Монгол цэргийн баярын өдрийн арга хэмжээний хүрээнд “Идэвхтэй амьдралын ирээдүй” клубын нэрэмжит шилжин явах цомын төлөөх “Гар бөмбөг”-ийн тэмцээн, ЗДТГазрын дарга Б.Сарантуяа ЕБ-Сургуулийн хүүхдүүдэд “Тусгаар тогтнолын үнэ цэнэ” лекц орж, баярын парад жагсаалыг

зохион байгууллаа. Цэрэг спортын “Буухиа” тэмцээн, Модон морин дээгүүр харайх тэмцээн, “Ханьдаа хүргэх сэтгэлийн үг” захидлын уралдаан, “Эх орон танаа” дууны тэмцээнийг тус тус зохион байгууллаа.

МӨРӨН СУМ

Залуучуудын оролцоог хангасан “Мини” хуралдаан зохион байгуулж тэдэнд тулгамдсан 3 асуудлыг шийдвэрлэхээр хэлэлцэв.

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг сумын хэмжээнд зохион байгууллаа.

Цагаан толгой багийн нутаг дэвсгэрт мал амьтаны галзуу өвчин гарсантай холбогдуулж багийн засаг дарга айл өрхүүдээрээ тойроход нь 67 ширхэг объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг өгч сумын төвийн айл өрхүүдэд тарааж сурталчлан ажиллаа.

Малын галзуу өвчин гарсантай холбогдуулан 14 хоногийн хязгаарлалтын дэглэм Засаг даргын А/15 тоот захирамжаар тогтон, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Сэрэмжлүүлгийг хязгаарлалтын бүсэд буй 8 өрхөд тараан, ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн.

БАЯНМӨНХ СУМ

2018 он буюу Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд хийсэн ажлаараа Баянмөнх сум “ Шилдэг сум ”-аар шалгарч шагналаа гардан авлаа. Мөн Залуу малчин Шилдэг гэр бүл, Авьяаслаг гэр бүлүүд тодорсон.

“ Эрүүл мэнд – Хөдөлгөөн – Хөгжил ” дэд хөтөлбөрийг хэрэгжилтийг хангаж ажлын хүрээнд зохион байгуулагдсан “ Хөдөлгөөнөөр эрүүлжицгээе ” сарын аянд 3-р байранд шалгарч шагнагдлаа.

Баянмөнх суманд ЗДТГ, ИТХ, Малчдын бүлэг холбооны ахлагч нартай хамтран Мал Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам сэдэвт зөвлөгөөн, Мянган шагайн баяр уламжлалт өв соёлын арга хэмжээ амжилттай боллоо.

ЗДТГазар ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн сурагчдад “ Найрсаг харилцаа ” сургалтыг Ведийн математик, хурууны математик, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль сэдвээр зохион байгуулж, 53 сурагч хамрагдлаа.

Сар шинийн баяртай холбогдуулан сумын 60 - аас дээш насны ахмадуудад УИХ-ын гишүүн Дархан аварга Б.Бат-Эрдэнэ, 75-аас дээш насны ахмадуудад УЛСЫН АВАРГА МАЛЧИН Ж.Энх-Амгалан, 80-аас дээш насны ахмадуудад сумын Засаг дарга М.Цэнгэл, 90-ээс дээш насны ахмадад аймгийн Засаг дарга Н. Ганбямба гарын бэлэг өгч хүндэтгэл үзүүлээ.

Сар шинийн баярыг угтан “Цэвэрхэн шинэлцгээе” уриан дор нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, ЗДТГазраас өндөр настан Б.Юра, Б.Алтангэрэл, Л.Ундрал нарын өрхөд хөрзөн татаж өглөө.

Сумын нэгдсэн шинэлгээ, УБ хотын нэгдсэн шинэлгээ зохион байгуулж, сумын хамгийн өндөр настай Н.Долгор гуайд сумын удирдлагууд золгон хүндэтгэл үзүүлсэн. СУМЫН АВАРГА МАЛЧИН-аар Баянбулаг багийн малчин Бямбаагийн Цогтгэрэлийн гэр бүл, Хэрлэн багийн малчин Хөхнохойн Батзулын гэр бүл, Дулаан багийн малчин Ичинхоролын Энхмөнхийн гэр бүл, мянгат малчнаар Батнасангийн Буяндалайгийн гэр бүл тус тус шалгарч шагналаа гардан авсан.

Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дугаар 189 "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай" тогтоолыг аж ахуй нэгжид танилцуулан хориглосон нийтлэг уутыг зарахгүй байхыг анхааруулан баталгаа авч ажиллалаа.

Жаргалтхаан сумын ЕБС-тай сурагч солилцоо ажлыг зохион байгуулж 10 сурагчийг явуулаад байна.

БОР-ӨНДӨР СУМ

2019 оны 03 дугаар сарын 03-ны өдөр "Миний эх орон-Миний бахархал" эх орончдын баярт зориулсан эссе бичлэгийн уралдаан зохион байгуулагдлаа.

ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Эмэгтэйчүүдийн манлайлал” сэдэвт лекцийг Монголын лекторуудын холбооны тэргүүлэгч Лектор Ж.Сайнбаяр хөтлөн явуулсан бөгөөд Бор-Өндөр сумын “Эрхэмсэг эмэгтэйчүүд”-ийн цэнгүүнийг зохион байгууллаа.

Аврах, гал унтраах 49-р ангиас зохион байгуулсан “Гал түймрээс урьдчилсан сэргийлэх ТАРХАЛТ”-ын сургалтад Засаг даргын Тамгын газрын албан хаагчид амжилттай оролцлоо.

Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Бор-Өндөр Цогцолбор сургуулийн "Есүхэй мэргэн" буудлагын клубд "Ирээдүйн эх орончид" уриан дор БӨЦС-ийн 10-12 дугаар ангийн эрэгтэй сурагчдын дунд хийн урт бууны төрлөөр буудлагын тэмцээнийг ЗДТГ, "Есүхэй мэргэн" буудлагын клубын мастер багш нар хамтран зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль Бор-Өндөр суманд зохион байгуулагдлаа.

БАТНОРОВ СУМ

Олон улсын “Кенгуру” олимпиадад 4-10 –р ангийн 43 сурагч оролцов.

Боловсролын үнэлгээний төвөөс “Жайка” төслийн удирдах зөвлөлийн дарга Б.Мөнхдэлгэр, БСУГ-ын мэргэжилтэн Х.Байгалмаа нар ЕБ-Сургуулийн 3,9,10 дугаар ангиудаас сонгогдсон сурагчдаас математик, монгол хэл, хүн орчин, хөгжим, хими, газар зүй, англи хэлний хичээлээр шалгалт, сонгогдсон сурагчдын эцэг эхчүүдээс судалгаа авлаа. Хүүхдийн цэцэрлэг “Бид бүгдээрээ бүжигчид” бүжгийн наадамд 7 бүлгийн 180 хүүхдүүд оролцлоо.

Назофарингитийн урьдчилан сэргийлэх үзлэгийг цэцэрлэг, сургуулийн нийт багш болон эцэг эхчүүдэд “Менингококкт халдвар” сэдвээр сургалт зохион байгуулж, зөвлөмж боловсруулан өгсөн. Шүдний үзлэгийг 500 хүүхдэд хийж өвчлөлийг тогтоов. Нийт хүүхдийн 54,2 хувь нь шүдний өвчлөлтэй байна.

БАЯН-АДРАГА СУМ

Баян-Адарга сум нь Гэр бүл хүүхэд залуучуудын жишиг сумаар сонгогдсон бөгөөд энэ ажлын хүрээнд ГБХЗХГ-ын ажлын хэсэг суманд ирж сургалт сурталчилгааны ажил, мөн Жишиг сум нээлт хийв. ДЗМОУБ-ын “Бор-Өндөр-2” ОНХ төгсөлтийн аргачлал болон гэрээр айлчлагч хөтөлбөрт хамрагддаг айл өрхүүдэд сургалт хийж, хүндэтгэлийн хүлээн авалт хийлээ. Лектор Азбаяр иргэдэд Гэр бүлийн үнэ цэнэ сэдвээр сургалт хийлээ

“Дуулах өв 2019”, “Хүрэл тулга 2019”, “Гоо охин”, “Бяцхан мисс” тэмцээнүүд болж 90 шахам оролцогч, 400 үзэгч хамрагдлаа.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч Э.Сарандаваа, их эмч Н.Гүлнур, эх баригч бага эмч А.Энхтөвшин нар ЕБС болон хүүхдийн цэцэрлэгт назофарингитийн урьдчилан сэргийлэх

үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгт нийт 302 хүүхэд хамрагдлаа. Элэгний В вирусын сайн дурын дархлаажуулалтанд нийт 10 иргэн дахин дархлаажуулалтад 60 иргэн хамрагдлаа.

ДАДАЛ СУМ

2019.02.01-ний өдөр малчдын 12-р зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулав. Тус зөвлөгөөнд Баян-Овоо, Онон, Балж, Агац багуудын нийт 100 гаруй малчид, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид оролцлоо. Аймгийн аварга малчнаар Балж багийн малчин Чимэддоржийн Батболд, аймгийн аварга ногоочноор Балж багийн ногоочин Бадарчингийн Оюунтуяа, 2018 оны сумын аварга малчнаар Балж багийн малчин Адьяагийн Болор-Эрдэнэ нар шалгарав.

Сар шинийн баярыг тохиолдуулан бүх албан хаагчид, ЕБС, Цэцэрлэгийн сурагчдын дунд “Дээлтэй Монгол” өдөрлөгийг 7 хоногийн турш зохион байгуулав. Үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон нэг байгууллагыг сумын Засаг даргын гарын бэлгээр шагнаж урамшуулав.

Ахмадын дуун цэнгүүн зохион байгуулж, тус сумын удирдлагууд харьяалалгүй 198 ахмадууддаа хүндэтгэл үзүүллээ.

Хилийн 0287 дугаар анги, ОХУ-ын Мангутын хэсгийн хилийн бүрэн эрхт төлөөлөгч нарын Монголын уламжлалт цагаан сарын баярыг хамтатган тэмдэглэх хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулж, уг үйл ажиллагаанд цэцэрлэгийн бэлтгэл А, дунд А бүлгийн хүүхдүүдийн хамтлаг бүжиг, гоцлол дуу, шүлгээр концерт тоглож сонирхуулав.

02-р сарын 16-ны өдөр сумын бүх нийтийн биеийн тамирын өдөрлөг “ЦАС МӨСНИЙ БАЯР-2019” тэмцээнийг албан байгууллага, ААН-үүдийн дунд зохион байгууллаа.

02.15-18-ны өдрүүдэд цэцэрлэгийн багш нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор 7 бүлгийн багшийн дунд “Багшийн манлайлал” сэдэвт ур чадварын уралдааныг 4 төрлөөр зохион байгуулав.

“ЭРГЭХ ХОЛБОО-23” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “Балжийн андууд” мөсний шагай, олон төрөл тэмцээнд Баян-Овоо, Бэрх, Галшар, Баян-Адрага, Баянхутаг, Биндэр, Дадал сумын Балжийн андууд, Цагаан булаг ХХК, Хилийн цэргийн 0287 дугаар ангийн нийт 9 багийн 150 гаруй тамирчид хоёр өдрийн турш 12 төрлөөр өрсөлдөв.

“МОНГОЛ БИЧГЭЭР ХЭРХЭН ЦЭВЭР БИЧИХ ВЭ” аяныг албан байгууллагын ажилчдын дунд амжилттай зохион байгуулав. Уг үйл ажиллагаанд нийт 150 орчим төрийн албан хаагчид оролцлоо.

Хүүхдийн цэцэрлэгийн бүлгийн багш нарын нэрэмжит 100 буудалт даамны тэмцээн 02.26-ны өдөр зохион байгуулж, 7 бүлгийн 14 эцэг, эх оролцов.

БИНДЭР СУМ

Онон голын сав дагуух сумдын "Мөсний загасчлал"-ын гурав дахь удаагийн тэмцээнийг Биндэр сумын ЗДТГ, "Онон голын загасчдын клуб" ТББ, "Номадик жонис" ХХК хамтран 03-р сарын 02 нд Биндэр сумын нутаг Онон голд зохион байгууллаа.

Биндэр сумын сайн дурын ажилтан эмэгтэйчүүд, хүүхэд хөгжлийн төвөөс санаачлан ЗДТГ, ДЗМОУБ-тай хамтран "Хөгжилд бид түүчээлье" эмэгтэйчүүдийн уулзалт, зөвлөгөөнийг 03-р сарын 07 нд амжилттай зохион байгууллаа.

03-р сарын 11-ний өдөр сумаас аймгийн төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгч Ц.Дэмбэрэлсайхан аймгийн ИТХ-ын дарга Л.Батсайхан, нарийн бичгийн дарга С.Бат-Эрдэнэ, Орон нутгийн хурал хариуцсан ажилтан Ш.Эрдэнэжаргал нарын хамт ирж "Төлөөлөгчийн өдөр"

арга хэмжээг суманд анх удаа зохион байгууллаа. Сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, иргэдтэйгээ уулзаж тулгамдаж буй асуудал, албан хаагчдын санал хүсэлтийг сонсож 2017-2018 онд хийсэн ажлын мэдээллээ танилцууллаа.

Уг арга хэмжээний үеэр төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор ахмад багш Д.Лхагвасүрэн, Алтан гадас одонгоор Улсын аварга малчин Г.Сүхбаатар, Хөдөлмөрийн хүндэт медалиар 3-р багийн Засаг дарга С.Золзаяа нар шагнагдсаныг гардуулан өгч баяр хүргэлээ.

Ойн нөхөрлөлүүдийн ахлагч, гишүүд, идэвхтэн байгаль хамгаалагчдад Ой ашиглалт, хамгаалалт, Зөрчлийн тухай хуулиудын талаар сургалт, зөвлөгөөнийг "Биндэр-Ой" сум дундын ойн ангитай хамтран 03-р сарын 11-нд зохион байгуулж Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ойн нөхөрлөлүүд, идэвхтэн байгаль хамгаалагчидтай "Ой хээрийн түймрийн аюултай улиралд хамтран ажиллах гэрээ" байгуулан тэдний эргүүл харуул хийх. ухуулга сурталчилгаа зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэн 16 идэвхтэн байгаль хамгаалагчдад тус бүрт А-80 бензин 20 литрийг БОХНС зардлаас санхүүжүүлж зөвлөмж, чиглэл өглөө.

03-р сарын 11-нээс 14 ний өдрүүдэд календарьчилсан төлөвлөгөөний дагуу багийн өдөрлөгүүд сумын төвд зохион байгуулагдлаа. Өдөрлөгийн үйл ажиллагаанд сумын удирдлагууд, мэргэжилтнүүд, байгууллагын дарга нар оролцож цаг үеийн ажлын талаар мэдээлэл өгч иргэдийн санал хүсэлтийг сонсож, ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх ажлын санал авах ажлууд хийгдсэн байна.

Эрдэм боловсролтой Биндэрчүүд хөтөлбөрийн хүрээнд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг сумын Засаг даргын нэрэмжит олимпиад энэ жил "Сэтгэх чадвар"-ын төрлөөр 03-р сарын 15-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Энэхүү арга хэмжээнд 2 -11 дүгээр ангийн нийт 220 сурагч, 23 эцэг эхчүүд оролцлоо.

УИХ-ын гишүүн, Зам тээврийн сайд асан М.Зоригтын ахалж яваа "Бидний цөөхөн Монголчууд" төслийн багийнхан 03-р сарын 15-18-нд Биндэр суманд ажиллав.

"Бидний хүч- Биндэрийн хөгжил" ТББ-аас санаачлан Аймгийн БСУГ, сумын ЕБС хамтран ахмад багш С. Очир агсны нэрэмжит физикийн олимпиадыг хойд бүсийн сумдын сургуулийн 9-р ангийн сурагчдын дунд 03-р сарын 16 ний өдөр зохион байгууллаа. 1сая төгрөгийн шагналын сантай энэ олимпиадыг С. Очир агсны үр хүүхдүүд ивээн тэтгэсэн байна.

Сумын ИТХ-аас санаачлан "Аавуудын өдөрлөг" арга хэмжээг ЕБС, Цэцэрлэг, Цагдаагийн тасаг, Бор-Өндөр-2 ОНХ-тэй хамтран 03-р сарын 16-нд сумандаа анх удаа амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагаанд 300 гаад аавууд оролцож, "Ааваа дуулъя" дууны тэмцээн, "Аавдаа захидал бичээрэй" захидлын, "Аав бид хоёр" фото зургийн уралдаанууд болсон бөгөөд уралдааны шагналтнууд захидлаа уншиж, дуугаа дуулж, бүтээлч ажил өрнүүлэв.

Ахмад багш Г.Үржинсүхийн санаачилгаар эх орон, ард иргэдийнхээ төлөө тэмцэж явсан ахмад дайчдынхаа алдрыг хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор Дайчин алдрын танхимыг ЕБС дээр байгуулж, Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Монгол цэргийн өдөр буюу 03-р сарын 18 нд ард

түмнийхээ тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөөх тэмцлийг харуулсан самбарыг байрлуулах үйл ажиллагаа явагдлаа.

03-р сарын 18-нд Биндэр суманд “Дэлхийн бүс” ТББ-ын санаачилгаар сумын ЗДТГ, Ардчилсан нам, Соёлын төвтэй хамтран “Аймгийн аварга шалгаруулах” цэнгээнт бүжгийн тэмцээнийг зохион байгууллаа. Уг тэмцээнд Хэрлэн, Баян-Адрага, Биндэр сумын 26 хос оролцож, өрсөлдөв.

Сумын Хүн эмнэлгээс 35-45, 46-65 насны урьдчилан сэргийлэх багцын үзлэг шинжилгээнд 65 хүн хамруулсан бөгөөд Донорын хүрээг өргөтгөж бүлэг тус бүрд донортой болох зорилгоор албан байгууллага, ААН-н ажилчин албан хаагчдыг цусны бүлэг тодорхойлох болон урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 39 хүн хамруулснаас 29 иргэн донорт элсэх боломжтой болсон.

Дэлхийн эмч нарын өдрийг угтан сумын удирдах албан тушаалтнууд 03-р сарын 26 ний өдөр “Хишиг өдөр” үйл ажиллагаа явууллаа.

03-р сарын 28, 29 ний өдрүүдэд хойд бүсийн сумдын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгах “Аврагч” тэмцээн тус сумын нутаг Биндэрийн овоонд боллоо.

БЭРХ ХОТ

Бэрх тосгоны захирагчийн алба болон албан хаагчдад нийт 53 албан бичиг ирснээс хугацаагүй 27, хариутай нь 20, хугацаа болоогүй 6, шийдвэрлэсэн 18 бичигт хариуг хүргүүлсэн байна.

Монгол улсын шадар сайд бөгөөд улсын онцгой комиссын дарга Ө.ЭНХТҮВШИН, ОБЕГ-ын тэргүүн дэд дарга, бригадын генерал Г.Ариунбуян нараар ахлуулсан улсын Онцгой комиссын бүрэлдэхүүн, аймгийн Засаг дарга Н.Ганбямба нар 2019 оны 3 дугаар сарын 8-ны өдөр бэрх хотод ажиллаж, иргэд, хөдөлмөрчид, нутгийн удирдлагуудтай уулзалт хийв.

"Эргэх холбоо-24" хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Бэрх хотын Захирагчийн ажлын алба, "ЭРГЭХ ХОЛБОО" ТББ хамтран зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн төлөө эмэгтэйчүүд” уулзалт цэнгүүнд бэрх хотын нийт 340 гаруй эмэгтэйчүүд оролцлоо.

Монгол улсын засгийн газрын 67, 339, 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд жил бүрийн гурав дугаар сарын 4 дэх 7 хоногийн пүрэв гарагийн 16:00 цагт улс орон даяар явагддаг зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургуулийг амжилттай зохион байгуулж, нийт 14 техник хэрэгсэлтэй 512 албан хаагч, иргэд, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд хамрагдлаа.

МУ-ын Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам”-ын дагуу Бэрх хотын шинэ хаягжуулалтын 7,5 сая төгрөгийн үнэ бүхий 242 ширхэг тэмдгийг "Геомэл" ХХК-аар хийлгүүлэн, 51 барилга, 36 гудамж, 155 ширхэг хаалганы дугаарыг өөрсдийн хүчээр байршуулав.

Бэрх хотын захирагч Ч.Чинбат, "Гурван Бухтын Толгод" ТББ-ын тэргүүн Д.Цэндсүрэн нар жоншны нөхөрлөлийн ахлагч нартай уулзаж бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд ханган ажиллах Засгийн газрын 151 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар хэлэлцлээ.

“Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээг олон нийтэд хөнгөн шуурхай ил тод нээлттэй хүргэх зорилгоор Захирагчийн ажлын албаны “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2019-03-06-ны өдөр зохион байгуулж мэргэжилтнүүд, иргэдэд шинээр гарсан хууль, журмыг танилцуулж, 45 иргэн үйлчилгээ авлаа.

ЖАРГАЛТХААН СУМ

Эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх оролцоог сайжруулах, гэр бүлийн үнэ цэнэ, хүүхдийн хүмүүжлийн талаар эерэг зөв хандлагыг бий болгож, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сумын ЗДТГ-аас санаачлан, ДЗМОУБ-ын "Орон нутгийн хүүхэд хамгаалал" төсөлтэй хамтран “ҮНЭ ЦЭНЭТЭЙ МОНГОЛ ЭМЭГТЭЙ” өдөрлөгийг 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр амжилттай зохион байгуулж, 300 эмэгтэйчүүд оролцлоо.

“Цэвэр тохилог Жаргалтхаан” хөтөлбөрийн хүрээнд Жаргалтхаан тохижилт-үйлчилгээ ОНӨААТҮГ-аас сумын төвийн хогийн цэгийг түрж цэгцлэн золбин нохой устгах ажлыг зохион байгуулж, нийт 61 золбин нохойг устган булж, ариутгал халдваргүйтгэл хийлээ.

Архидалтгүй Жаргалтхаан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “ СПИРТЭЭС ТАТГАЛЗАЖ, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭЦГЭЭЭ” уриан дор насанд хүрэгчдийн сумын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн 2019 оны 03 сарын 09-10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Уг тэмцээнд 17 багийн 136 тамирчид 48 багц медалийн төлөө хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс эрэгтэй багийн төрөлд Б.Батзориг ахлагчтай төвийн багийн тамирчид 1-р байр, эмэгтэй багийн төрөлд Ц.Одгэрэл ахлагчтай Баян-Эрдэнэ багийн тамирчид 1-р байр эзэлж, Шилдэг тоглогчоор Б.Амгаланбаяр, Ж.Гангантөгс нар шалгарлаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, ХАА-Тасаг, Эрүүл мэндийн төвтэй хамтран ЕБС-ийн үдийн цай, дотуур байрны хоолны чанар, илчлэг, нормативт хяналт шалгалт хийж, холбогдох дүрэм журмыг танилцуулж, зөвлөмж өгч ажиллаа. Сумын Засаг дарга Б.Цогт-Орших, Засаг даргын орлогч С.Ганбат, ЗДТГ-ын дарга Л.Цэнгэл нар 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Хүүхдийн цэцэрлэгт ажиллан багш ажилтнуудад 2019.03.18-ны 9/480 дугаартай албан бичиг, Төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтны ёс зүйн дүрэм, багшийн ёс зүйн дүрмийг танилцуулж, баталгаа гаргуулан үүрэг чиглэл өгч ажиллаа.

ДЭЛГЭРХААН СУМ

2019 оны 3 сарын 04 -нд Баянхаан баг, 3 сарын 5-нд Хэрлэнтооно баг, 03 сарын 6-нд Долоод баг тус тус ИН-Хурал зохион байгуулагдлаа. Хурлын үер Багийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт 2018 оны тайланг хэлэлцүүлж дүгнүүлэх, Багийн хилийн цэс батлах, “Иргэдийн оролцоотой-Шинэ Хэнтий” төслийн танилцуулга, Цагаатгалын тухай, Дундын сан байгуулах, багийн иргэд одон медаль шагналд тодорхойлох зохион байгуулалт зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Мөн сумын ИТХ, ЗДТГ-ын албан хаагч нар цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч, санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.

“Монгол улс” төрийн ууган байгууллагын бодлого шийдвэрийг намын гишүүд дэмжигчдэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах “Эх орончдын баяр”-ыг тэмлдэглэн өнгөрүүлэх,

хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх зорилгоор ЕБС, ЗДТГ,ИТХ-тай хамтран Эх орончдын баярын өдрийг зохион байгууллаа.

ӨМНӨДЭЛГЭР СУМ ГУРВАНБАЯН ТОСГОН

Гурванбаян тосгонд 3-р сарын 6-нд Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан ЕБ-Сургуулийн багш ажилчид “Бодлын наран ээж”, “Ээждээ бичих захидал” уралдаан явууллаа.

Эмэгтэйчүүдийн зөвлөл хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулахад Хэнтий аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч П.Жавзанрагчаа,Ч.Алтанзаяа нар хүрэлцэн шагнал гардуулан эмэгтэйчүүдийн дунд сугалаа сугалуулж, 10000 төгрөгийн эзэн 5, 20000 төгрөгийн эзэнээр 3 хүн, манжуур аялах эзэнээр нэг хүнийг тодруулав.

Монгол цэргийн баярыг угтан “Яг өнөөдрөөс гэр бүлдээ” Гэрээр айлчлагч-Хүүхэд хамгааллын төслийн өрх гэр бүлүүдэд сургалт хийсэн бол өдрийн үйл ажиллагаа ньтосгоны зөвхөн эрчүүддээ сургалт лекц үргэлжиллээ.

ХЭРЛЭН СУМ

Хэрлэн сумын төсвийн орлого төлөвлөгөөний дагуу 3-р сард 206.3 сая төгрөг төвлөрөхөөс 3 дугаар сарын 20-ны байдлаар 208.8 сая төгрөг төвлөрч орлого 100.8 %-ийн гүйцэтгэлтэй байна. Хэрлэн сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийгдэж байна. Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч Ц.Идэрбат, аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулууны хамт Наурызын баярыг тохиолдуулан Өлзийт тосгонд зочилж, Казах түмэнтэйгээ уулзаж баярын мэндчилгээ дэвшүүллээ.

“Тэмүүжин” цогцолбор сургуулийн танхимд Халх голын дайны ялалтын 80 жил, Монгол цэргийн өдөр"-ийн 98 жилийн ойн байрыг тохиолдуулан Хэрлэн сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб тус сургуулийн захиргаатай хамтран ДАЙЧИН АЛДАРЫН БУЛАНГ нээлээ.Монгол орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалахын төлөө халуун амь, бүлээн цусаа үл хайрлан тэмцэж явсан дайчдаа алдаршуулах, өсвөр үеийнхэнд их түүх, эх нутгаа хайрлах, эрх чөлөө, тусгаар тогтнолын үнэ цэнэ, үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор уг ажлыг зохион байгууллаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Хэрлэн сумын ЗДТГ, Хэрлэн сумын Эмэгтэйчүүдийн холбоо хамтран аймгийн спортын ордонд "Баярлалаа ээжээ" 1000 ээжийн баярыг ёслол төгөлдөр зохион байгууллаа. Тус ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааны хүрээнд 3 хүү төрүүлсэн "Дархан бэр", 3 охин төрүүлсэн "Уран бэр" нийт 45 сайхан ээжийг тодруулан батламж, өргөмжлөл, дурсгалын зүйлсээр шагнаж урамшууллаа. Тус арга хэмжээнд "Хэнтийн мэдээ сонин", Хэнтий" ТВ, "Өндөрхаан" ТВ хамтран ажилласан.

Хэрлэн сумын Эмэгтэйчүүдийн холбооноос Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх жилийн хүрээнд "Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг Хэрлэн сумын 6 багийн эмэгтэйчүүдийн зөвлөлүүдтэй хамтран баг тус бүр дээр зохион байгуулсан.

Хэрлэн сумын хамтарсан багийн дунд "Хариуцлагатай хамтарсан багийг чадавхижуулах" сургалтыг ДЗОУБ-ын Бор-Өндөр 2 хөтөлбөрөөс Хэрлэн сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж байна. Сургалтын чиглүүлэгч багшаар хамтарсан багийн үндэсний сургагч багш Д.Ундраа ажиллаж, хэсгийн ахлагч нарыг хэрхэн чадавхижуулах, хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтарсан багийн үйл ажиллагааг чиглүүлэх, нийгэм буюу иргэн өрх бүрийг төрийн үйл ажиллагааны нэгжүүдтэй харилцахад хэрхэн холбож болох талаар илтгэл, кейсүүд дээр хамтран ажиллаж байна.

"Өөрчлөлтийг өөрөөсөө эхлүүлье" ХХҮГазраас санаачлан зохион байгуулсан сарын аяны хүрээнд зохиогдсон явган аялалд төвийн 6 баг буухиа тэмцээн, хурд хүч авхаалж самбаагаа сорин тэмцэлдэж Цогт-Өндөр баг 3 байр эзэллээ.

Гадаад харилцааны чиглэлээр: Хөлөнбуйр дүүргийн Хайлаар хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд сумын ИТХурлын төлөөлөгчдийг тус хотод албан айлчлал хийлгэн туршлага судлууллаа.

Байгаль орчны чиглэлээр: 3-р сарын 15,16-ны өдрүүдэд Хэрлэн сумын төвийн 6 багт Хаврын их цэвэрлэгээг ААН албан байгууллагууд болон айл өрхүүд хуваарийн дагуу зохион байгууллаа.

Энэ өдрүүдэд 6 багийн нийт 142 ААН байгууллага 38,3 тонн, айл өрхүүд 44,5 тонн хогийг тус тус цэвэрлэж, эгнээ гудамж, зам талбайн нийтийн их цэвэрлэгээг хийсэн.Хэрлэн сумын ЗДТГ, багууд аймгийн ОБГазрын гал унтраах аврах 032-р ангитай хамтран 1,2,3,5,6-р багуудад эгнээ гудамж, зам талбайд ихээр хуримтлагдсан хамхуул хазаар өвсийг шатааж устгах ажил хийгдлээ.

Хэрлэн сумын нутаг дэвсгэрт бичил уул уурхай эрхлэгч 5 нөхөрлөл болон шинээр өргөдөл өгсөн нөхөрлөлүүдэд сумын байгаль орчны мэргэжилтэн, аймгийн Хариуцлагатай бичил уурхай эрхлэгчдийн холбоо хамтран сургалт зохион байгууллаа.

ХАА-н чиглэлээр: Морин уралдаан зохион байгуулахыг хориглосон шийдвэрийг багуудад мэдэгдэж малчдад танилцуулан ажилласан.

Хэрлэн суманд нохой ,муур тэжээдэг айл өрх ААН-ийн судалгааг гарган гэрчилгээжүүлэн төлбөр хураамж авах ажлын хэсгийн захирамжийг гарган журмыг шинэчлэн засварлан 750 ш гэрчилгээг багуудад тараасан.

1-6 дугаар багийн малчдад баг тус бүр 80 боодол өвс . Одоогоор 551 ногоон өвс тааран олгоод байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Хэрлэн сумын Баянмөнх багийн 6-р гудамж иргэн н.Наранхүүгийн хашаанд үхсэн үнэгийг аймгийн Мал эмнэлгийн шинжилгээний лабораторын шинжилгээнд оношийг тодруулахад галзуу өвчин гэсэн онош гарсан тул тус эгнээний ойр орчмын айлуудад ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил хийсэн.

Хэрлэн сумын Баянмөнх багийн 82 өрхийн 166 өрхөд галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх гарын авлага тараан ажилласан.

Хэрлэн сумын төвд гарсан галзуу өвчин гарсантай холбогдуулан 1-6 дугаар багийн 27 өрхийн 895 үхэр, 497 өрхийн 667 нохойг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамрууллаа.Мөн галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх зааврыг 553 өрхийн 1027 иргэдэд хүргүүлсэн.Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 1 хүүхдийг хамруулсан.

Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газартай хамтарч нохой устгалыг зохион байгууллаа. Үүнд 529 нохойг устгаж , ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэлээ.

СХ-Сан, ЖДБДСангийн чиглэлээр: Хэрлэн сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны үйл ажиллагаанд Хэнтий аймгийн ЗДТГ-ын Санхүүгийн хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс шалгалт орж байгаа бөгөөд шаардлагатай материалуудыг гаргаж өгч ажилласан.

Зээлдэгч нартай нэг бүрчлэн утсаар холбогдож СХ-Сангийн дансанд 20 гаран сая төгрөгийг төлүүлээд байна.

Мөн хугацаа хэтэрсэн удаа дараалан шаардаад төлөөгүй 20 –оод зээлдэгчийн материалыг бүрдүүлэн Шүүхэд өгөхөөр бэлдээд байна. Шүүхийн захирамж нь гарсан боловч хугацаандаа төлөөгүй 30-аад зээлдэгчийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд өгөхөөр бэлдэж байна.

Төсөл хүлээж авах зарыг 2019 оны 3 сарын 7-ны өдрөөс 3 сарын 20-ны хооронд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулан одоогоор 10-аад төсөл ирээд байна.

ЖДБД-Сангийн зээлийн дансны үлдэгдэл 13,000,0 төгрөг байснаас Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны Шүүх дэх Эвлэрүүлэн зуучлах хэсэгт хандан шийдвэрлүүлсэн 22 зээлдэгчийн эвлэрлийн гэрээний биелэлтийг утсаар холбогдон шаардаснаар 5 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдэж өнөөдрийн байдлаар 18,500,0 төгрөг болоод байна.

Дэд бүтцийн чиглэлээр: Дахин төлөвлөлтийн 174 айлын орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТ-Хурлаар батлуулсан бөгөөд төслийг боловсруулж ажлын хэсгээр хэлэлцүүлэн өдрийн сонинд зарлуулсан.

18 иргэний алдагдсан эд зүйлсийн үнэлгээг хийсэн.

Өндөрхаан багийн төвийн болон эко автобусны гражийн байршлын асуудлыг шийдвэрлүүлсэн.

Багуудын чиглэлээр: Хан Хэнтий чуулгад болсон “Бидний цөөхөн Монголчууд” төслийн арга хэмжээний нээлтэд 10 иргэн, 2019.03.08-нд болсон “Гэр бүлийн лекцэд” 24 иргэн, ХХҮГ, ДЗМОУБ-ын хамтарсан “Өөрчлөлтийг өөрөөсө эхэлье” сургалтад зорилтод бүлгийн 38 иргэнийг тус тус хамруулсан. Хэрлэн сумын 1 дүгээр баг нь олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, цэргийн баярыг тохиолдуулан “Зүрхнээс эгшиглэх дуун цэнгүүн” арга хэмжээг зохион байгуулж 160 гаруй иргэд оролцлоо. Мөн багийн эмэгтэйчүүдийн зөвлөл “Тэнгэрлэг эрчүүд” фото зургийн уралдаан зохион байгуулж 1-3-р байр эзлүүлэн шагнал, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.

1-р баг нь Хэнтий ЦТС-Салбартай хамтран нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, эрчим хүчний тухай хууль, ЦЭХ-ний бичилт, орлого, цахилгаан тасалдал, үнэ тариф зэргээр мэдээлэл хийлгэж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Тус үйл ажиллагаанд 100 гаруй иргэд хамрагдлаа. Хэрлэн сумын 3 дугаар баг нь ОУ-ын эмэгтэйчүүдийн баярыг угтан Лаборатори 1-р сургуулийн 10-12-р ангийн сурагчдын дунд “Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдаан зарласан. Мөн “Сүүн замтай ээж” баярын үйл ажиллагааг 2019.03.06-ны өдөр “Солонго” нийтийн бүжгийн заланд зохион тус тус зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр багийн “Өнөр гэр бүл”, “Хөдөлмөрч гэр бүл”, “Авьяаслаг гэр бүл”, Ээждээ захидал бичээрэй уралдааны дүнг гарган 1,2,3,4-р шалгаруулан тус тус шагнаж урамшуулсан.

2019 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын хяналтын тоог баг тус бүр аймгийн Цэргийн штабт хүргүүлсэн.

НАЙМ. ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

САЙТЫН МЭДЭЭ: Төрийн мэдээллийн www.Khentii.mn сайтад 19 мэдээ, 2 сурвалжилга, төвийн мэдээллийн сайтууд болох www.zindaa.mn, www.montsame.mn, www.khentiinews.mn Монголын сайтуудын холбооны бүртгэлтэй 14 сайтад давхардсан тоогоор 9 ярилцлага, 32 мэдээ, 14 тодруулга, өргөн нэвтрүүлгийн сувгаар 9 мэдээ бэлтгэн нийлүүлэв.

ТВ-ийн МЭДЭЭ: Орон нутгийн Хэнтий, Өндөрхаан ТВ-ийн сурвалжлагчдаар нийт 6 мэдээ бэлтгэж, эфирт болон нийгмийн сүлжээнд байршуулав. МҮОНРТВ-ийн Монголын мэдээ-гийн орон нутгийн сурвалжлагчаар 3 мэдээ бэлтгүүлэв.

“Шинэ зууны Хэнтий” сонинд 2018 оны ажлын тайлантай холбогдуулан дөрвөн нүүр тусгай дугаар 1200 ширхэг хэвлэж, иргэдэд хүргэв.